



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2022 /10/НА-СТА-ОНТС

Цахим хуудас:
www.audit.mn
Эрдэнэт хот
2022 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Эрдэнэ
Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn
Аудитор: Д.Цогбадрах
Утас: 70350757 Цахим хаяг: tsogbadrakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1.Санал дүгнэлт.....	2
САНАЛ ДҮГНЭЛТ	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
3. Аудитын тайлан	6
3.1 Ерөнхий зүйл	6
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	7
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	8
3.8 Аудитын гол асуудал	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
4. Аудитын илрүүлэлт.....	9
4.1 Залруулсан алдаа	9
4.4 Зөвлөмж	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

САНАЛ ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 94

танай _____-ны № _____-т

ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.ЗОРИГТБАЯР ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	256,712,982.00	261,314,919.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	41,570,010.00	89,447,565.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	41,570,010.00	89,447,565.00
3121	Төгрөг	41,570,010.00	89,447,565.00
31211	Төрийн сангийн харилцах	41,570,010.00	89,447,565.00
33	АВЛАГА	215,142,972.00	171,867,354.00
335	Бусад авлага	215,142,972.00	171,867,354.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	215,142,972.00	171,867,354.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	256,712,982.00	261,314,919.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	231,800,000.00	231,800,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	231,800,000.00	231,800,000.00
413	Өглөг	231,800,000.00	231,800,000.00
4136	Бусад өглөг	231,800,000.00	231,800,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	231,800,000.00	231,800,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,912,982.00	29,514,919.00
51	Засгийн газрын хувь оролцоо	24,912,982.00	29,514,919.00
512	Хуримтлагдсан үр дүн	24,912,982.00	29,514,919.00
51210	Өмнөх үеийн үр дүн	19,872,727.00	24,912,982.00
51220	Тайлант үеийн үр дүн	5,040,255.00	4,601,937.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	256,712,982.00	261,314,919.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,040,255.00	4,601,937.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,040,255.00	4,601,937.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,040,255.00	4,601,937.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	5,040,255.00	4,601,937.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,040,255.00	4,601,937.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	5,040,255.00	4,601,937.00
5	НИЙТ ҮР ДҮН	5,040,255.00	4,601,937.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			19,872,727.00	19,872,727.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	19,872,727.00	19,872,727.00
C07	Тайлант үеийн үр дүн			5,040,255.00	5,040,255.00
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	24,912,982.00	24,912,982.00
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	24,912,982.00	24,912,982.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	24,912,982.00	24,912,982.00
D08	Тайлант үеийн үр дүн			4,601,937.00	4,601,937.00
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	29,514,919.00	29,514,919.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/
			Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	74,867,297.00	105,977,555.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,867,297.00	105,977,555.00
120	Нийтлэг татварын бус орлого	74,867,297.00	105,977,555.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,867,297.00	105,977,555.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	74,867,297.00	105,977,555.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	74,867,297.00	105,977,555.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	54,500,000.00	58,100,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	54,500,000.00	58,100,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(54,500,000.00)	(58,100,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	20,367,297.00	47,877,555.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,202,713.00	41,570,010.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41,570,010.00	89,447,565.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Цогбадрах гүйцэтгэж хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 03/44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сум хөгжүүлэх сан нь зээлийг иргэдэд хуулийн дагуу олгох, түүний эргэн төлөлтөд хяналт, тавих эрсдлийг бууруулах зорилго бүхий Засаг даргын харъяа нэгж юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХууль тогтоомжид өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн, төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв болох 170,645.6 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 3,412.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг өөрчлөөгүй бөгөөд 80 хувиар буюу 2,730.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад өөрчлөөгүй болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,602.0 мянган төгрөгөөр буюу 1.02 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	41,570.0	89,447.5	47,877.5
Авлага	215,142.9	171,867.4	(43,275.5)
Нийт хөрөнгө	256,712.9	261,314.9	4,602.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	24,912.9	29,514.9	4,602.0
Өр төлбөр	231,800.0	231,800.0	0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	256,712.9	261,314.9	9,204.0

Мөнгөн хөрөнгийн дансанд зээлийн эргэн төлөлтөнд нийт 101,375.6 мянган төгрөг, зээлийн хүү төлөлтөнд нийт 4,602.0 мянган төгрөгийн орлого орсон нь өмнөх оноос 1.4 хувийн өсөлттэй байна.

Авлага нь 16 зээлдэгчийн 43,275.5 мянган төгрөгийн зээл хаагдаж өмнөх оноос 7.9 хувиар буурсан байна.

Сумын иргэд, аж ахуй нэгж байгууллагаас 22 төсөл ирснээр 2021 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар 7 төсөл дэмжигдэж 57,000.0 мянган төгрөгийн зээлийг олгохоор шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Мал аж ахуй чиглэлээр 3 төсөлд 21,000.0 мянган төгрөг
- Газар тариалангийн чиглэлээр 2 төсөлд 17,000.0 мянган төгрөг
- Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн чиглэлээр 2 төсөлд 19,000.0 мянган төгрөгийн зээлийг тус тус олгоод байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 438.3 мянган төгрөгөөр буюу 9.1 хувиар буурсан байна..

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай. Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сан нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээ мэдээллийг ил тод байршуулахаас 3 мэдээллийг огт мэдээлээгүй, 19 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээ мэдээллийг ил тод байршуулахаас 3 мэдээллийг огт мэдээлээгүй, 19 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн харин зарлагын гүйлгээ хийхдээ цахим төлбөрийн е-баримтгүй, анхан шатны баримтын бүрдэлгүй, Санхүүгийн тайлан, тодруулга тэмдэглэлийг сангийн сайдын холбогдох тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Шилэн дансны тухай хуулийн 6.1-д энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д "заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн

дотор мэдээлнэ” хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 215,142.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	215,142.9	1	215,142.9			
Нийт дүн	1	215,142.9	1	215,142.9			

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 90,874.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 700.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 90,174.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

700.0 мянган төгрөгийн шатах тослох материал зарлагадахдаа НХМаягт БМ-6 маягт ашигладаггүй, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар"-тай нийцэхгүй байна.

4.3 Албан шаардлага Байхгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

2. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Сум хөгжүүлэх сангаас 2011 оноос хойш олгосон 14 зээлдэгчийн 80,900.0 мянган төгрөгийн зээлийн эргэн төлөлт хугацаа хоцролттой, зээлийн үлдэгдлийг зээлдэгч тус бүртэй тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.5.3-д “энэ журмын 3.5.2-т заасан төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зохих журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах”, 4.7-д “иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө”, 5.2-д “сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгана”, 6.3-д “энэ журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээд хариуцан барагдуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн зарцуулалтад үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол, журмын хэрэгжилтийг хангуулах. Санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу гэм буруутай этгээдээр хариуцан барагдуулах.

2.3. Илрүүлэлт:

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сан нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээ мэдээллийг ил тод байршуулахаас 3 мэдээллийг огт мэдээлээгүй, 19 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-д энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д “заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.4. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд хугацаа хоцролгүй мэдээлж байх.

2.5. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлан, тодруулга тэмдэглэлийг сангийн сайдын холбогдох тушаалаар баталсан журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй. Мөн аккруэл болон мөнгөн суурьт шалгах баланс гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.1-д “нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь” гэж мөнгө хүлээн авсан, эсхүл төлсөн эсэхээс хамаарахгүйгээр орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг”, 4.1-д “аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө”, 14.3-д “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ”, 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

2.6. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланг олон улсын стандартын дагуу иж бүрэн гаргах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Жаргалант сумын Сум хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жаргалант сумын Сум хөгжүүлэх сан	4	90,874.8			1	700.0			3	90,174.8